

“ХҮНДЭТ ДОКТОР” ЦОЛ ОЛГОВ*Ж.Орхон**

Монгол Улсаас АНУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Р.Болдын урилгаар тус улсын Төрийн нарийн бичгийн дарга асан, ноён Жеймс Бейкер 2006 оны 3-р сарын 18-22-ны хооронд манай улсад айлчлав.

Айлчлалын үеэр Ж.Бейкер, Техас мужийн Хьюстон хотын Райсын Их сургуулийн захирал Эдвард П.Джейреджан болон дагалдан яваа хүмүүсийн хамт ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнд зочилж, тус хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачидтай уулзаж ярилцав. Уулзалтанд ШУА-ийн Ерөнхийлөгч, академич Б.Чадраа, ОУСХ-ийн захирал, доктор, профессор Л.Хайсандай, Монгол Улсаас АНУ-д суугаа элчин сайд Р.Болд, доктор, профессор Д.Цахилгаан, МУИС-ийн ОУСХ-ийн захирал, доктор Н.Алтанцэцэг, доктор, профессор Ш.Арвай, ГХЯ-ны албаны зарим хүмүүс болон тус хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачид оролцов.

Ноён Ж.Бейкер хүрээлэнгийн бүтэц, судалгааны чиглэл, эрхлэн гаргаж буй ном бүтээлүүдтэй танилцаж, эрдэмтэн судлаачидтай санал санал солилцож, хамтран ажиллах судалгааны ажлын чиг шугамыг тодорхойлж, тавьсан асуултанд хариулж, цаашид тус хоёр хүрээлэн хамтран ажиллах болсонд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. Уг уулзалтан дээр Ж.Бейкер Монгол дахь АНУ-ын ашиг сонирхол юу вэ? гэсэн судлаачын асуултанд хариулахдаа: “АНУ-ын Монгол дахь ашиг сонирхол бол миний анхны айлчлалын үед байснаасаа өөрчлөгдөөгүй. АНУ-ын эрхэмлэн дээдэлдэг үнэт зүйлс болох ардчилал, чөлөөт зах зээлийг дэмжих нь Америкийн сонирхол байсан, хойшид ч байх болно” гэж цохон тэмдэглэв.

Уулзалтын үеэр АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан, ноён Ж.Бейкерт АНУ ба Монгол Улсын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг үүсгэн хөгжүүлэх үйлсэд их хувь нэмэр оруулсаны учир ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн “Хүндэт доктор” цолоор өргөмжлөв. Монгол Улс, АНУ-ын харилцаанд түүний оруулсан хувь нэмэр нэн өндөр бөгөөд ялангуяа 1990-ээд оноос манай улсад өрнөсөн ардчилсан шинэчлэл, өөрчлөлтийн үйл явцад АНУ гурав дахь хөршийн байр сууринаас хандан, дэмжлэг тусалцаа үзүүлж ирсэн нь ноён Жеймс Бейкерийн хүч чармайлттай салшгүй холбоотой юм.

* Ж.Орхон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Мөн уулзалтын үеэр Райсын их сургуулийн захирал Эдвард Джейреджан хэлсэн үгэндээ “АНУ нь Монгол Улсын гурав дахь хөршийн хувьд Зүүн хойд Азийн орон байж болох юм. Тиймээс Монголын судлаач, эрдэмтэдтэй хамтран тус бүс нутаг дахь түлш, эрчим хүчний геополитикийг судлахыг санал болгож байна” хэмээн онцолж байв. Техас мужийн Райсын их сургууль нь 1993 онд байгуулагдсан бөгөөд эрдмийн зөвлөлийн гишүүдэд нь Колин Пауэлл, Мадлен Олбрайт, Дэвид Либрон, Уилям Барнетт зэрэг АНУ-даа улс төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүмүүс байдаг аж. Судалгааны ерөнхий чиглэл нь төрийн бодлогын асуудал бөгөөд Ойрхи Дорнод, хятад судлал, олон улсын харилцаа үүнд Орос, хоёр Солонгос болон Япон зэрэг улсын бүс нутгийн судалгаа, Мексикийн хил орчмын асуудал, Ойрхи Дорнодын усны асуудал, Ирак дахь дайн ба терроризм үүнд АНУ-ын гадаад, дотоод бодлогыг тодорхойлох, Арабын ертөнц дэх Израиль-Палестины асуудал, Ангараг гариг дээрх судалгаа зэрэг олон талт судалгааны ажил хийхийн зэрэгцээ эдүгээ 2-3 жилийн хугацаатай “Үндэсний газрын тосны компанийн олон улсын эрчим хүчний зах зээлд эзлэх байр суурь” хэмээх судалгааг хийж байгаа ажээ.

Айлчлалынхаа үеэр Ж.Бейкер Ерөнхий сайд М.Энхболдод бараалхаж, Шадар сайд М.Энхсайхантай уулзсан бөгөөд Монгол Улсын ерөнхийлөгч асан Н.Багабанди түүнийг халуун дотноор хүлээн авч ярилцжээ.